НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2009 оны 9 сарын 1 өдөр Дугаар 452 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн үйл ажиллагаанд шинэчлэлт хийх, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор шаардлагатай тоног төхөөрөмж, нэгдсэн програм хангамжийг бүрдүүлэх, байнгын хэвийн чанартай үйл ажиллагааг хангах, зардал хэмнэх зорилгоор "Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр.Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн аливаа үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагад даалгасугай.

Гурав.Дээрх журмыг хэрэгжүүлэхэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, хамтарч ажиллахыг нийслэлийн Мэдээллийн технологийн газар /Ш.Гантөмөр/-т үүрэг болгосугай.

Дөрөв.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Б.Баатарзоригт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Г.МӨНХБАЯР

81

Нийслэлийн Засаг даргын 2009 оны
9 дүгээр сарын 1-ны өдрийн
452 дугаар захирамжийн хавсралт

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагууд /цаашид "ННЗБ" гэх/ нь мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн аливаа үйл ажиллагааг шинээр хийж хэрэгжүүлэх, нэвтрүүлэх болон цаашдын байнгын үйл ажиллагааг ханган ажиллахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2.Энэхүү журмын зорилт нь дээрхи 1.1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Мэргэжлийн эрх бүхий байгууллага болон Нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг тогтоон зохицуулахад оршино.

1.3."Мэдээллийн технологи" гэж аливаа электрон хэлбэрээр илэрхийлэгдсэн өгөгдөл, мэдээ, мэдээллийг бүтээх, хадгалах, боловсруулах, дамжуулах, илэрхийлэх зорилго бүхий техник ба програм хангамжийн тогтолцоог хэлнэ.

1.4.Мэргэжлийн эрх бүхий байгууллага нь нийслэлийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллага байна.

1.5.Мэргэжлийн эрх бүхий байгууллага энэ журмын хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй.

Хоёр. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн ажил үйлчилгээг шинээр хийх, шинэчлэн сайжруулах

2.1.Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээг шинээр хийх, шинэчлэн сайжруулахад ННЗБ-дын үүрэг:

2.1.1.Байгууллагынхаа үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, сайжруулах санал санаачлага гаргаж төсөл хөтөлбөрүүдийг боловсруулан мэргэжлийн эрх бүхий байгууллагаас мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллах;

2.1.2.Шаардлагатай зардлыг жил бүр байгууллагынхаа төсөвт суулгуулж байх;

2.1.3.Шинээр хийж хэрэгжүүлж буй ажлуудыг чанаржуулах, хяналтыг сайжруулах, байнга гардаг зардлыг бууруулах, нэгдсэн бодлогод уялдуулах үүднээс техникийн болон програмын даалгавар, шаардлагыг мэргэжлийн эрх бүхий байгууллагатай хамтарч боловсруулах;

2.1.4.Тодорхой ажлуудыг мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсаны үндсэн дээр гүйцэтгүүлэх;

2.1.5.Хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж буй ажлын явц, гүйцэтгэлд мэргэжил арга зүйн хяналтыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх;

2.1.6.Тухайн байгууллага нь ажлыг бүрэн хэрэгжүүлсний дараа шинээр хэрэгжүүлсэн ажлынхаа зохиогчийн эрхийг эзэмшиж, баримт бичиг, эх кодын нэг хувийг мэргэжлийн эрх бүхий байгууллагын гаргасан шаардлагад нийцүүлэн хүлээлгэж өгөх;

2.1.7.Ажлынхаа шинэчлэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь мэргэжлийн эрх бүхий байгууллагад өгч баримтжуулж хадгалуулна.

2.2.Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээ шинээр хийх, шинэчлэн сайжруулахад мэргэжлийн эрх бүхий байгууллагын үүрэг:

2.2.1.Байгууллагуудын санаачилсан төсөл, хөтөлбөрүүдийг судалж нэгдсэн бодлоготой уялдуулан, шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх, гадаад, дотоод санхүүжилт олоход мэргэжлийн дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах;

2.2.2.ННЗБ-дыг мэдээллийн технологийн дэвшил, шинэ технологи, тоног төхөөрөмжийн талаарх шинэлэг мэдээллээр хангах;

2.2.3.Нийслэл хотын хэмжээнд мэдээллийн технологийг ашиглах арга замыг өргөжүүлэн сайжруулах, шинээр нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах;

2.2.4.Гэрээ байгуулж тодорхой төлбөртэйгээр програм, техник хангамжуудыг шинээр хийх болон засвар үйлчилгээ, сервер, сүлжээний ажлыг гүйцэтгэх;

2.2.5.ННЗБ-дад хийгдэж буй ажлуудын техник болон програмын даалгаврыг боловсруулах, хүлээлцэх ажилд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтарч оролцох:

2.2.6.ННЗБ-дад шинээр хийж хэрэгжүүлж буй ажлуудыг чанаржуулах, хяналтыг сайжруулах байнга гардаг зардлыг бууруулах, нэгдсэн бодлогод уялдуулах үүднээс ажил гүйцэтгэх гурвалсан гэрээ, хүлээлцэх актын загварыг гаргаж хэрэгжүүлэх;

2.2.7.Гурвалсан гэрээний дагуу хяналт тавьж оролцсон ажлын чанар, гүйцэтгэлийг Нийслэлийн Засаг даргын өмнө тухайн байгууллагатай хамт хариуцах;

2.2.8.Тогтоосон хүрээнд хяналт хийж, дүгнэлт гарган нийслэлийн удирдлагуудад тогтмол танилцуулж, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах;

2.2.9.ННЗБ-дын захиалгаар шинээр нэвтрүүлж, хэрэгжүүлж байгаа програм, техник хангамжийн баримт бичиг, эх кодын нэг хувийг хадгалах;

2.3.Нийтлэг ашиглагддаг програм, техник хангамжуудын хувьд:

2.3.1Нийслэлийн төсвөөр хийгдсэн нийтлэг ашиглагддаг програм, техник хангамжуудыг үйл ажиллагаа, үйлчилгээний зардлаас өөр үнэ төлбөргүйгээр нэвтрүүлэх;

2.3.2.Нийтлэг ашиглагддаг програм техник хангамжуудыг байгууллага өөрсдөө санаачлан хэрэгжүүлж буй үед бусад байгууллагуудтай гэрээ байгуулж төлбөр тооцоог тохиролцож нэвтрүүлэх;

2.3.3.Дээр дурдсан ажлуудыг гүйцэтгэхдээ тухайн байгууллагын онцлог, давуу талуудыг тусгах;

2.4.Эх код, зохиогчийн эрхийг нь эзэмших боломжгүй хэрэглэгч байдлаар ашиглаж буй ажлын хувьд 2.1.6, 2.1.7, 2.2.9 дэх заалтыг мөрдөхгүй.

Гурав. Хөгжүүлэх, байгын үйл ажиллагааг хангаж ажиллах

3.1.Шинээр болон шинэчлэн сайжруулсан тоног төхөөрөмж, програм хангамжийг тухайн байгууллага нь өмчдөө бүртгэж хөгжүүлэлт, байгын үйл ажиллагаа, мэдээллийн шинэчлэлтийг бүрэн хариуцаж ажиллана.

3.2.ННЗБ-дын сүлжээний чиглэлээр хийгдсэн ажлуудын дотоод сүлжээ нь тухайн байгууллагын өмч байх бөгөөд гадаад сүлжээ нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын өмч байна.

3.3.Нийслэл нь вэб, мэйл, сервер програмуудыг байрлуулах нэгдсэн сервертэй байх ба тэдгээрийн байгын үйл ажиллагааг мэргэжлийн эрх бүхий байгууллага хариуцан ажиллана.

3.4.Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээг хөгжүүлэх, байгын үйл ажиллагааг ханган ажиллахад нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үүрэг:

3.4.1.Тухайн байгууллага дээр ажиллаж байгаа техник, програм хангамжуудыг мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцүүлэн шинэчлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4.2..Програм, техник хангамж, сервер, сүлжээний ажлуудыг шинээр хийлгэх, хөгжүүлэх болон цаашдын байгын үйл ажиллагаа засвар үйлчилгээг мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж тодорхой төлбөртэйгээр гүйцэтгүүлэх;

3.4.3.Мэргэжлийн эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжээр тодорхой гэрээтэйгээр хөгжүүлэлт, байгын үйл ажиллагааг хариуцуулан ажиллах;

3.4.4.Вэб суурьтай програм хангамж болон сервер програмуудыг нэгдсэн серверт байрлуулах;

3.4.5.Улаанбаатар хотын нэгдсэн портал http://www.ulaanbaatar.mn болон Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн http://www.mayor.mn

вэб сайтуудад өөрийн байгууллагын мэдээ мэдээлэл болон өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүрд нь шуурхай гаргаж өгч байх;

3.5.Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн ажил үйлчилгээг хөгжүүлэх, байнгын үйл ажиллагааг ханган ажиллахад мэргэжлийн эрх бүхий байгууллагын үүрэг:

3.5.1.Гэрээт байгуулагуудын мэдээллийн технологийн дэд бүтцийн өөрчлөлт шинэчлэлт, байнгын найдвартай үйл ажиллагааг ханган ажиллах;

3.5.2.ННЗБ-дын вэб хуудас, програм хангамжийн шинэчлэлтийг мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцүүлэн тухайн байгууллагын хүсэлтийн дагуу хөгжүүлж байх;

3.5.3ННЗБ-дад хийгдсэн ажлын баталгаат хугацаа дуусан үед техник, програм хангамж нь гэмтсэн, засварлах байнгын үйл ажиллагааг хангах шаардлага гарсан үед мэргэжлийн эрх бүхий байгууллага нь тухайн байгууллагын хүсэлтийг үндэслэн баримт бичиг, эх кодын дагуу үйлчилгээ үзүүлэх;

3.5.4.Компьютер тоног төхөөрөмжийн шаардлага хангах дотоод өгөгдөл стандартыг гаргаж жил бүр шинэчилж байгууллагуудад мэдээлэх;

3.5.5.Ашиглалтын шаардлага хангахгүй болсон компьютер, тоног төхөөрөмж болон гадаад дотоод сүлжээнд стандарт шаардлагын дагуу мэргэжлийн дүгнэлт гаргах;

3.5.6.Мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлийн сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

3.5.7.Нийслэлийн нэгдсэн сервер дээр засвар хийх, аливаа техникийн саатал, гэмтлийг арилгах зорилгоор серверийн үйл ажиллагааг түр зогсооход гэрээт байгууллагуудад урьдчилан мэдэгдэнэ.

3.5.8.Улаанбаатар хотын нэгдсэн портал http://www.ulaanbaatar.mn болон Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн http://www.mayor.mn вэб сайтуудын байнгын найдвартай ажиллагааг хариуцан ажиллах;

3.6. "Хангарьд ордон"-ны сервер, сүлжээ, холбоо, дохиололын системийн тоног төхөөрөмжүүдийн байнгын найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллахад байгууллагуудын үүрэг:

3.6.1. Мэргэжлийн эрх бүхий байгууллага нь "Хангарьд ордон"-ны тоног төхөөрөмжүүдийн байнгын найдвартай үйл ажиллагааг хангаж, хариуцаж ажиллах;

3.6.2. "Хангарьд ордон"-ны тоног төхөөрөмжүүд нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын өмч бөгөөд байрлаж буй байгууллагууд нь байрандаа засвар шинэчлэл хийх тохиолдолд заавал урьдчилан мэдэгдэх;

3.6.3.Тухайн байгууллагын эзэмшил хэсэгт байрлаж буй тоног төхөөрөмжүүдийн байрыг өөрчлөх, задлах, засварлахыг хориглох;

3.6.4."Хангарьд ордон"-д байрлаж буй байгууллагуудын албан хаагчид нь

сүлжээ, холбооны эвдрэл гэмтэл гарсан үед Мэргэжлийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн анхан шатны оношлогооны гарын авлагын дагуу засварлах оношлох үүрэгтэй;

3.6.5.Гарын авлагын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Мэргэжлийн эрх бүхий байгууллагад хандана;

3.6.6."Хангарьд ордон"-ы тоног төхөөрөмжүүдийн байнгын үйл ажиллагааг хангаж ажиллахад шаардлагатай журмыг Мэргэжлийн эрх бүхий байгууллага нь санаачлан боловсруулж хэрэгжүүлж ажиллана.

3.7.Албан хаагч ажлаас чөлөөлөгдөх, халагдах үед хэрэгцээт файл, програмыг хүлээлцэхгүй байх мөн вирус, гадны халдлагаас хамгаалах үүднээс байгууллагууд дотоод журамдаа дараах зүйлсийг заавал тусгана:

3.7.1.ННЗБ-ууд нь Мэдээллийн технологи, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжлийн боловсон хүчинтэй байх ба тухайн мэргэжилтнийг ажилд авах, томилохдоо мэргэжлийн эрх бүхий байгууллагатай зөвшилцөх;

3.7.2.ННЗБ-ууд нь бичиг баримт, хэрэгцээт мэдээлэл, файл, програм, ажилтан албан хаагчдын шаардлагатай файлуудыг хадгалах, өөрсдийн эрхээр хандаж орж байх дотоод сүлжээнд ажиллах тусгай сервер компьютерыг ажиллуулна.

3.7.3.Дээрхи сервер компьютерт буй мэдээллийг тусгай тоног төхөөрөмжид улирал бүр нөөцөлж хадгална.

3.7.4.Албан хаагч ажлаас чөлөөлөгдөх, халагдах зэрэг ажил хүлээлцэх тохиолдолд тухайн ажлын байранд холбогдолтой мэдээлэл, файл, тусгай програмыг заавал хүлээлцэнэ.

3.7.5.Ажил хүлээлцэх хуудасны загварыг мэргэжлийн эрх бүхий байгууллага боловсруулж байгууллагуудад хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээллийн сангийн бүтэц, үйл ажиллагаа

4.1.Мэдээлэл, харилцаа холбоо технологийн чиглэлийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох төсөл хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн бодлогоор хангах, зорилгоор мэдээллийн санг дараахь бүтэцтэйгээр зохион байгуулна:

- Тоног төхөөрөмжүүдийн сан
- Програм хангамжуудын сан
- Сүлжээний мэдээллийн сан
- Төсөл хөтөлбөрүүдийн сан

4.2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг мэргэжлийн эрх бүхий байгууллага эрхэлнэ.

4.3. ННЗБ-ууд нь дараа жилийн шинээр хийж хэрэгжүүлэх ажлынхаа санал, төслийг сангийн үйл ажиллагааг эрхлэн явуулж буй байгууллагад жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор ирүүлнэ.

4.4.Энэ журмын 4.1-д заасан сангуудын өөрчлөлт шинэчлэлтийн мэдээг хувийн хэрэгт заасны дагуу жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор сангийн үйл ажиллагааг эрхлэн явуулж буй байгууллагад гаргаж өгнө.

4.5.ННЗБ-ууд нь компьютер тоног төхөөрөмж, програм хангамжид хувийн хэрэг хөтөлнө.

4.6.Техник хангамж, компьютер тоног төхөөрөмжийн хувийн хэрэг нь зориулалт, хүчин чадал, үйлдвэрлэсэн он, өөрчлөлт шинэчлэлт, засвар үйлчилгээ, бүтээгдэхүүний үнэ, марк, сериал, хариуцсан ажилтан гэсэн мэдээллийг агуулна.

4.7.Програм хангамжийн хувийн хэрэгт зориулалт, бичигдсэн програмчлалын хэл, хэмжээ, ажиллах систем, бүтээгдсэн он, өөрчлөлт шинэчлэлт, гүйцэтгэсэн байгууллага, бүтээгдэхүүний үнэ гэсэн мэдээллийг агуулна.

4.8.Нэг тоног төхөөрөмж, програм хангамжид зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө.

4.9.Хувийн хэрэг хөтлөх загвар, зааврыг мэргэжлийн эрх бүхий байгууллага тогтооно.

Тав. Төлбөрт үйлчилгээ үзүүлэх

5.1. Мэргэжлийн эрх бүхий байгууллага нь ННЗБ-уудтай гэрээ байгуулсаны үндсэн дээр дараах мэдээллийн технологийн үйлчилгээнүүдийг төлбөртэйгээр зохион байгуулна. Үүнд:

a) Вэб суурьтай програм хангамж хийх
b) Мэдээллийн сан, хэрэглээний програм хангамж хийх
c) Серверийн үйлчилгээ үзүүлэх
d) Дотоод сүлжээ, дотуур холбооны засвар үйлчилгээ
e) Компьютер, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
f) Мэдээллийн технологийн сургалт

5.2.Дээрх төлбөрт үйлчилгээнүүдийн үнэ нь зах зээлийн дундаж үнийн дүнгийн *50* хувиас ихгүй байна.

5.3.Дээрх үйлчилгээнүүдийн төлбөр, үйлчилгээний нөхцлийг гэрээгээр зохицуулна.

Зургаа. Төлбөрт үйлчилгээнээс олсон орлогыг зарцуулах

6.1.Төлбөрт үйлчилгээнээс олсон орлого нь нийслэлийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулахад зарцуулагдана.

6.2.Үйл ажиллагааны орлогыг зөвхөн 6.1-д заасан зориулалтаар зарцуулна.

Долоо. Хариуцлага

7.1.ННЗБ-ууд нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн програм, техник хангамжийн ажил үйлчилгээний баримт бичиг, эх кодын нэг хувийг

Мэргэжлийн эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөөгүйгээс гарах аливаа үр дагаварыг тухайн байгууллага бүрэн хариуцна.

7.2.Мэдээллийн аюулгүй байдал, нууцыг тухайн байгууллага хариуцна.

7.3.Мэргэжлийн эрх бүхий байгууллага нь тухайн байгууллагын мэдээллийн технологийн чиглэлийн дотоод ажилд мэргэжлийн хяналт тавихаас өөрөөр хөндлөнгөөс оролцох, төсөл хөтөлбөрүүдийг заавал өөрийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг шаардахыг хориглоно.

7.4.Энэхүү журмыг зөрчсөнөөс тухайн байгууллагад учирсан хохирлыг шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан хариуцна.

7.5.Энэхүү журмыг баримтлан ажиллаагүй ННЗБ-дын удирдлагад хариуцлага тооцох асуудлыг Мэргэжлийн эрх бүхий байгууллага нь эрх бүхий албан тушаалтанд гаргана.

7.6.Энэ журмын хэрэгжилт, зөрчилтэй холбоотой санал, гомдлыг байгууллага, хувь хүн нотлох баримтын хамт мэргэжлийн эрх бүхий байгууллагад болон нийслэлийн удирдлагуудад ирүүлж болно.

Найм. Бусад зүйл

8.1.Энэхүү журамд тусгагдаагүй бусад харилцааг холбогдох эрх зүйн акт, гэрээний дагуу зохицуулна.

8.2.Гарсан маргааныг хууль тогтоомж энэхүү журамд заасны дагуу мэргэжлийн эрх бүхий байгууллага, хариуцсан НЗД-ын орлогч хянан шийдвэрлэнэ.